



НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 02 сарын 14 өдөр

Дугаар А/26

Улаанбаатар хот

Барилгын бүртгэлийн үнийг
нэмэгдүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.2.4 дэх заалт, Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/460 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газраас ирүүлсэн 2022 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 3/326 дугаар албан бичгийн дагуу нийслэлийн төсвийн хөрөнгөөр хийгдсэн хавсралтад заасан засварын ажлын гүйцэтгэлийн дүн 131,163,459 (нэг зуун гучин нэгэн сая нэг зуун жаран гурван мянга дөрвөн зуун тавин ес) төгрөгөөр холбогдох барилгын бүртгэлийн үнийг нэмэгдүүлэн бүртгэхийг нягтлан бодогч (Н.Уранчимэг)-д зөвшөөрсүгэй.

2.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтэс (Б.Батбаяр)-т даалгасугай.

ДАРГА

М.БАЯРАА





Нийслэлийн Өмчийн харилцааны
газрын даргын 2022 оны 02 дугаар
Инх А/26 тушаалын хавсралт

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

д/д	Төсөл арга хэмжээний нэр	Байршил	Хийгдсэн ажил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэх үнэ, төг	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр
1	Нийслэлийн Улаанбаатар чуулгын тайзны засвар	СБД, 8-р хороо, Нийслэлийн төр захиргааны 5 дугаар байр	2020	ш	1	67,015,460	Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт /НЗД-ын 2020 оны А/460 дугаар захирамжийн хавсралтын 2-д/
2	Нийслэлийн Соёл урлагын газрын дотоод засвар	СБД, 8-р хороо, Нийслэлийн Соёлын төв өргөөний барилга	2020	ш	1	64,147,999	Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт /НЗД-ын 2020 оны А/460 дугаар захирамжийн хавсралтын 3-д/
	ДҮН					131,163,459	